



ДОРНОГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/151

Хонгор


Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэхь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 2022 оны 7/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Бумбат багийн нутаг дэвсгэрт Шар жирэм хэмээх хаягт Х=550503.1147 Y=5047150.7081, Х=550523.4505 Y=5046306.3027, Х=549781.7962 Y=5046327.7940, Х=549782.1073 Y=5047135.4441 байршилтай, 2970661 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай, 60.4 га газрыг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК (6177492)-д 40 жилийн хугацаатай газрын тос дамжуулах хоолойн халаах өргөх дундын 4-р станцын зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч иргэний эзэмшлийн газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгүүлэх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх, заасан газрын хэмжээ заагийг тогтоож, тэмдэгжүүлж бүртгэн, газар эзэмших эрхийн гэрчилгээ авахад нь хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Болортуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАНЗРАГЧ

4422010473